

## **МОНГОЛЫН АРДЧИЛСАН ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ:<sup>1</sup> АРДЧИЛСАН ХӨДӨЛГӨӨН ХЭЗЭЭ ЭХЭЛЖ, ХЭЗЭЭ ДУУССАН БЭ**

*Мураи Мүнэюки\**

### 1. Монголын ардчилсан хөдөлгөөний эхлэл

Тус өгүүлэлд ардчилсан хөдөлгөөний түүхэн ач холбогдлын талаар судлан тодруулах эцсийн зорилго тавьсан юм. Үүний тулд ардчилсан хөдөлгөөнийг цаг хугацааны үечлэлээр авч үзлээ. Тиймээс ардчилсан хөдөлгөөнийг утга агуулгынх нь талаас дараагийн өгүүлэлд нарийвчлан авч үзэх болно.

“Үнэн” сонины 1990 оны 1-р сарын 19-ний дугаарт бичсэнээр Монголын Ардчилсан Холбооны Зохицуулах Зөвлөлийн гишүүнээр С.Зориг /Зөвлөлийн дарга, МУИС-ийн аспирант/, Б.Энхтүвшин /орлогч дарга, МУИС-ийн лаборант/, Ц.Элбэгдорж /“Улаан-Од” сонины сурвалжлагч/, С.Амарсанаа /“Хөдөлмөр” сонины сурвалжлагч/, Л.Баасан /Гандан хийдийн лам/, Д.Нинж /Монголын Сэтгүүлчдийн холбооны ажилтан/, Э.Бат-Үүл /ШУА-ийн ажилтан асан/, Д.Сосорбарам /Драмын Академик Театрын жүжигчин/, Д.Энхбаатар /УБИС-ийн оюутан/ нар сонгогджээ.

“С.Зоригийн инээвхийлэл” /хуудас 30-31/ номонд эдгээр гишүүдээс гадна Г.Бошигт /Энхтайван Найрамдлын Байгууллагуудын холбооны ажилтан/, Л.Нямсүрэн /Улсын Барилгын газрын зургийн ажилтан/, Д.Билигт /Цахилгаан холбооны газрын ажилтан/, Д.Энхбаатар /Монголын цахилгаан холбооны газрын ажилтан/ нарыг “Ардчиллын 13” гэж нэрлэсэн байдаг<sup>1</sup>. Цөм 35-аас доош насны эдгээр залуус Үндсэн хуулиар хатуу хориглосон заалтыг зөрчин цуглаан хийсэн юм<sup>2</sup>.

Энэ нь 1989 оны 12-р сарын 10 буюу Дэлхийн Хүний Эрхийн өдөр байлаа. Ардчилсан Хөдөлгөөн ингэж эхэлсэн тухайд хэн ч маргахгүй болов уу. Асуудлын гол нь ардчилсан хөдөлгөөний төгссөн үе хэзээ вэ гэдэгт байгаа юм.

### 2. 1989 оноос эхэлж, өнөөг хүртэл үргэлжилж байгаа юу.

Юуны өмнө, Ардчилсан Холбооны Эвслийн Засгийн газар нь Ардчилсан Хөдөлгөөний үр дүн юм гэж үзэх хүмүүс байдаг /жишээлбэл Бямбасүрэн зэрэг/<sup>3</sup>. Энэхүү Ардчилсан Холбооны Эвслийн Засгийн газар нь миний дээр өгүүлснээр<sup>4</sup> IMF, ESAF-ийн төлөвлөгөөг үг дуугүй

\*Мураи Мүнэюки - Японы Осака Их сургуулийн профессор, монгол судлаач

дагаснаас үүссэн улс төрийн алдаа, эдийн засгийн уналт, хээл хахууль, Зоригийн амь насанд халдсан зэргээс шалтгаалан оршин тогтнох утга учраа ерөнхийдөө алдсан юм. Тэгэхлээр энэ бүхэн Ардчилсан хөдөлгөөний үр дүн гэж хэлэхэд хэцүү.

Хоёрдугаарт, ардчилсан хөдөлгөөнөөс төрж гарсан цөөн бус улс төрчид одоо ч үйл ажиллагаа явуулж байгаа болохоор, уг хөдөлгөөн өнөөдөр ч үргэлжилж байна гэж үзсээр ирлээ. Жишээлбэл “Өдрийн сонин”-ы 1999 оны 12 сарын 04, 08, 09, 11-ний өдрийн дугаарт нийтлэгдсэн “Ардчилсан Хөдөлгөөн өрнөсний Арван жилд /Баримтын товчоон/”-д уг материал нийтлэгдэх хүртэл буюу 2000 он хүртэлх Ардчилсан Хөдөлгөөний үйл явдлын хэлхээсийг цувралаар гаргажээ.

Мөн түүнчлэн 1990 оны 3-р сарын өлсгөлөнд оролцож байсан, сүүлд Ардчилсан холбооны Эвслийн Засгийн газрын үед /1996-2000/ Эрдэнэт үйлдвэрийн захирлын алба хашиж байсан /МАХН эрх барих үед тушаалаасаа огцорсон/ Дорлигжавын хэлсэнээр<sup>6</sup> Ардчилсан Нам ардчилсан хөдөлгөөний залгамжлагч байж чадах бизээ. Энэхүү Ардчилсан Нам нь<sup>7</sup> /3-р хэсэг/ Чингис хаан Их Монгол Улсыг байгуулсан цаг үетэй уялдуулан 2000 оны 12 сарын 6-нд шинээр зохион байгуулагдсан юм. Ардчилсан намын байгуулагдсан тухайд олон янзын тайлбар байдаг хэдий ч үнэндээ, түүнээс дараа жилийн 2001 оны 7-р сард болсон Ерөнхийлөгчийн сонгуулийн бодлоготой гүнзгий холбоотой байлаа. Тэгээд Ардчилсан намаас нэр дэвшүүлсэн Гончигдорж Ерөнхийлөгчийн сонгуульд ялагдсаны дараа, 2001 оны 9 сарын 23-наас 25-нд болсон Ардчилсан Намын Үндэсний Зөвлөлийн хуралаар Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар дүгнэж хэлэлцэн, намын хүч чадал доройтохоос болгоомжлон удирдлагын хариуцлагын асуудлыг тавилгүй өнгөрч, урьд нь хүчтэй сурталчилж ирсэн “Сүүдрийн Засгийн газар” = “хүчтэй сөрөг нам байгуулах” гэсэн санаа ч бодит хэрэг болж чадалгүй ялагдлаар төгссөн юм<sup>8</sup>. Үүнийг Ардчилсан хөдөлгөөнөөс урвасан явдал гэж хэлж ч болно. Баабарын судалгаагаар хийсэн “1999 оноос хойш 2001 онд Монголд инфляц хамгийн өндөр хувьтай байж, эдийн засгийн хямралыг улам гүнзгийрүүлсэн” хэмээн Ардчилсан Намын Улаанбаатар хотын хорооны илтгэлд<sup>9</sup> дүгнэснийг бодит байдалд нийцээгүй шүүмжлэл гэж Монгол банкны захирал Чулуунбат үгүйсгэсэн байна.

Энэ мэтчилэн Ардчилсан Нам Ардчилсан хөдөлгөөнийг залгамжлан үргэлжлүүлэх байр сууриа алдаж байна. Тийм байх хүсэл зориг ч мэдрэгдэхгүй байна. Мөн “хүчтэй” байх эрмэлзэл ч алга. Ийм

байдлыг шүүмжлэн А.Баасандорж “аливааг өөртөө сэтгэл ханамжтай байдлаар зохицуулах хувийн эрх ашгийг хөөцөлдөх нь ардчилалд хортой” гэж бичжээ. Тэгэхлээр Ардчилсан холбоо эвслийн Засгийн газрын үйл ажиллагаагаар Ардчилсан хөдөлгөөн мөхсөн юм. 2 дахь үеийг эхлүүлэх зорилгоор Оюун, Ганхуяг, Хулан, Билэгсайхан, Эрдэнэ нарын хүмүүс МҮАН-аас гарч Ардчилсан Намыг байгуулсан /2000.01.23/ юм. Энэхүү шинэ намынхаа тухай тэд “Монгол дахь Ардчиллыг үргэлжлүүлэн, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, нийгмийн амжиргааны түвшинг дээшлүүлэх, нийгмийн тогтолцоог хэвийн болгох<sup>11</sup> зорилготой хэмээн тодорхойлж байв<sup>12</sup>. Мөн түүнчлэн МҮАН-ыг хээл хахуульд хэт автагдсан гэж буруушааж байлаа<sup>13</sup>.

Гэвч Ардчилсан хөдөлгөөнийг сэргээх зорилготой эдгээр хүмүүс мөн хуваагдмал байдалд орж, одоо Зоригийн дүү Оюунаар удирдуулан Иргэний Зориг Намыг /2000.03.09-нд/ байгуулахад хүрсэн нь, өргөн олны дэмжлэг сулрахад нөлөөлсөн юм. Тухайлбал, 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Иргэний Зориг Намаас нэр дэвшигч Л.Дашнямын авсан санал 3.54 хувь байлаа. Дашрамд дурьдахад, өрсөлдөгч нар болох МАХН-аас нэр дэвшигч Багабанди 58.13 хувьтай, МҮАН-ийн нэр дэвшигч Гончигдоржийн санал 36.53 хувь тус тус байсан юм.

Тэгэхээр энэхүү “мөхсөн” ардчилсан хөдөлгөөнд чухам хэзээ бутарч хуваагдах үр хөврөл бий болсон бэ? Яг тэр үеийг л анхны ардчилсан хөдөлгөөний төгсгөл хэмээн авч үзэх нь 90-ээд оны түүхийг тодруулахад тустай болов уу.

### 3. /Улсын Бага Хурлын даргын Сонгуулийн үед Социал Демократ Намын Гончигдорж үзэл бодлоо өөрчилсөн нь /1989-1990 оны 9 сар хүртэл/

1990 оны 7-р сард Ардын Их Хурлын сонгуульд МАХН ялсаны дараа, байнгын ажиллагаатай Улсын Бага хурлын даргын /Улсын дэд Ерөнхийлөгчийг хавсран гүйцэтгэх/ сонгууль 9-р сарын 3-11-нд болсон юм. МАХН-аас Сайд нарын Зөвлөлийн дарга байсан Гунгаадорж, Ардчилсан холбооноос Зохицуулах зөвлөлийн дарга С.Зориг, Социал Демократ Намаас намын тэргүүн Гончигдорж нар нэр дэвшин, эхний санал хураалтаар Зориг, Гунгаадорж нар үлдсэн байлаа. Энэ үе хүртэл Ардчилсан холбооны тал харилцан зохицуулсан байдлаар нэр дэвшүүлэхээр МСДН-тай хэд хэдэн удаа улс төрийн яриа хэлцэл хийж, ганц Зоригийг нэр дэвшүүлэхээр мэрийлт гаргасан

хэдий ч энэ саналыг Гончигдорж зөвшөөрсөнгүй. Хэрэв өөрийн нэрийг татаж авбал байдал МАХН-д ашигтайгаар эргэнэ гэж Гончигдорж үзэж байсан юм. Үүнийг нөгөө талаас нь үзвэл Гончигдорж үзэл бодлоо өөрчилж эхэлснийг харуулах үү. Сонгуулийн дараа Зоригийн хэлснээр, Гончигдорж намуудын тактикийг зөв уялдуулж чадсан юм<sup>14</sup>. Нэгдлийг татан буулгах шийдвэрээр /1990.05/ өөрийн эрх мэдлээ алдаж буй орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүдийн /нэгдлийн дарга нар гишүүдийн талаас илүү хувийг эзэлж байв/ дэмжлэгийг хүлээж Гончигдорж сонгуульд ялсан билээ. Энэ цаг үеэс Ардчилсан Хөдөлгөөн тарж бутрах шинж тэмдэг илэрч эхэлсэн юм.

Энэхүү хагарал бутрал нь Зоригийн санаачилгаар 1991 оны 2-р сарын 24-нд Бүгд Найрамдах Нам байгуулагдсанаар бодит зүйл боллоо. Билэгсайханы тодорхойлсноор Зориг Бүгд Найрамдах Намыг байгуулсан нь Ардчилсан хөдөлгөөний дотор газар аваад байсан намын ялзрал, коррупци, хээл хахуулийг эсэргүүцэж, Монголын ардчилсан холбооны 2-р их хурал дээр шинэ консерватив үзлийг дэвшүүлсэн нь амжилтад хүрээгүй, харин ч Ардчилсан Холбооны Зохицуулах Зөвлөлийн даргаас огцрон, уг намыг байгуулахад хүргэсэн юм<sup>15</sup>. Гэвч Ардчилсан Хөдөлгөөний доторх хагарлыг ашиглан Зоригийг ганцаардуулах бодлого явагдаж байсан юм<sup>16</sup>.

Мөн Бямбасүрэнгийн Засгийн газрын үед /1990-1992/ тэргүүн шадар сайдаар Д.Ганболд, шадар сайдаар Дорлигжав нар ажиллах болсноор ардчилсан хөдөлгөөний хагарал улам ил тод болсон юм<sup>17</sup>.

Мөн сонирхолтой нь тухайн үе хүртэлх нөхцөл байдлын өөрчлөлтийн талаар МҮАН-ын түүх нь маш бүдэг, бараг бичигдээгүй байгаа юм<sup>18</sup>. Энэ нь Ганболдын өөрийнх нь үндсэн байгууллага болох Үндэсний Дэвшлийн Намын үзэл бодлыг тусгаж байна гэж хэлж болно

Тэгэхээр Бямбасүрэнгийн Эвслийн Засгийн газар нь, түүний өөрийнх нь хэлсэнчлэн “УИХ-ын сонгуулиар МАХН 60 хувийн санал авч ялалт байгуулж, дангаараа Засгийн газар байгуулах юм бол шинэ улс төрийн хүчнүүд нэгдэн сөрөг хүчин бий болж нийгмийн хагаралд хүргэнэ гэж ойлгогдож байна. Мөн тухайн үеийн нийгмийн уур амьсгал “ардчилсан холбоонд ч тодорхой хэмжээгээр засаглалыг хуваарилах хэрэгтэй”<sup>19</sup> байлаа. Гэвч энэ нь олон намын тогтолцоот улс төр хэмээн Ардчилсан Хөдөлгөөний анхны зорилгоос ангид байсан юм<sup>20</sup>. Тэр ч улгаараа Зоригийн хэлсэнээр “бид сөрөг нам байх болно”<sup>21</sup> гэсэн санаа нь Ардчилсан Хөдөлгөөний үндсэн зорилгод нийцэж байсан юм.

Тодруулбал, бодит байдал дээр Бямбасүрэн “Миний бодлоор чөлөөт, хараат бус нийгэм нь шинэ хөгжлийн суурь болно” гэж хэлснээрээ<sup>22</sup> Ардчилсан Хөдөлгөөний зорилготой нэлээд ойролцоо санааг илэрхийлж байсан юм. Гэвч хэрэг дээрээ түүний улс төрийн удирдлагын арга барил нь бие даасан, дангаараа удирдах шинж чанартай байв<sup>23</sup>. Эдгээр нь Зориг болон Бямбасүрэн нарын үзэл бодлын төстэй ба ялгаатай шинж чанарыг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, Зориг нь зарчмын зүйлүүд дээр зохицуулалт хийх, харин Бямбасүрэн нь бие даасан дангаараа удирдан шийдвэрлэх арга барилтай байсан гэсэн үг. Үүний тухай дараагийн өгүүлэлд нарийвчлан авч үзнэ.

### **Дүгнэлт**

1989 оны 12-р сарын 9-нд эхэлсэн Ардчилсан хөдөлгөөн нь, 1990 оны 9 сарын Улсын Бага Хурлын даргын сонгууль, Бямбасүрэнгийн Засгийн газрыг байгуулахад Ардчилсан хөдөлгөөний оролцоо зэргээс хамаарч өөрчлөгдсөн юм. Энэхүү өөрчлөлт нь Ардчилсан холбооны эвслийн Засгийн газрын үед /1996-2000/ хээл хахууль болж хувирсан байна.

Эцэст нь тэмдэглэж хэлэхэд Монголын Ардчилсан Хөдөлгөөн нь эхнээсээ аваад Манж Чин улсын дарлалд байх үед дарлагч ангийн өөдөөс эсэргүүцлийн хөдөлгөөн болж өрнөсөн, “Монголын малчин ардын хөдөлгөөн”-ий “хувьсгалт уламжлал”-ыг өвлөн авсан хөдөлгөөн байсан хэмээн миний бие үзэж байна. Энэ тухай дараагийн хэсэгт тодорхой дурдах болно.

### **Ишлэл, зүүлт:**

1. А.Чойжилсүрэн, “С.Зоригийн Инээвхийлэл”, Улаанбаатар, 1998, х.30
2. 1960 оны 7-р сарын 6-ний өдөр батлагдсан Үндсэн хуулиар ард түмний үндсэн эрхийг баталгаажуулжээ. Тухайлбал, 76-88-р зүйлд ард түмний үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулсан юм. Гэхдээ, 89-р зүйлд ард түмний үндсэн үүрэг бол социалист өмчийг хүндэтгэн үзэх /89.а/, социалист нийгмийн сахилга батыг мөрдөх /89.б/, социалист лагерийн эрх ашгийг эн тэргүүнд тавих /89.д/ талаар хуульчлан заасан юм. Үнэн хэрэгтээ, /түүх, геополитикийн хувьд/ дор дурьдсанчлан хуулийн нэмэлт өөрчлөлтүүд дараа дараалан гарч, эвлэлдэн нэгдэх, хурал цуглаан хийх эрх чөлөөг ихээр хязгаарлаж байлаа. Үүнд Д.Батаа, Монгол Улсын Үндсэн Хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд /1924-1992/, Улаанбаатар, 1998

3. Д.Бямбасүрэн, Үүрийн Жавар, Улаанбаатар, 1996, 123-р тал
4. Мураи Мүнэюки “1990 оны Монголын улс төр ба эдийн засаг”, “Монгору кэнкю”, №18
5. Дээрх өгүүлэл
6. “Өдрийн сонин” 2000.12.07
7. Өнөөгийн Ардчилсан Намаас гадна, Ардчилсан Нам гэдэг нам 1990 он, 2000 онд хоёр ч удаа байгуулагдаж байсан. Тиймээс 2000 онд байгуулагдсан Ардчилсан Нам нь гуравдахь Ардчилсан Нам болно.
8. “Хүчтэй сөрөг нам” гэдэг нь Ардчилсан хөдөлгөөний гол зорилтуудын нэг байсан юм. Үүнийг “Ардчилсан хөдөлгөөний түүх” хэмээх баримт бичгээс ч тодорхой үзэж болно.
9. Өөрөөр хэлбэл, Ардчилсан Холбооны Эвслийн Засгийн Газар / 1996-2000/-ын үед тогтмол өсөлттэй байсан GDP Засгийн газар солигдсноор буурсан хэмээн Баабар сануулсан юм.
10. “Зууны мэдээ” 2001.10.02
11. “Өнөөдөр” 2001.09.27
12. “Өдрийн сонин” 2000.01.15
13. “Өдрийн сонин” 2000.02.11, “Өдрийн сонин” 2000.01.24
14. Д.Дожоодорж, “Ардчилсан Хувьсгалын Удирдагчийг Хэн Хөнөөсөн бэ”, Улаанбаатар, 2000, х.110
15. Ардчилсан Хувьсгалын Удирдагчийг Хэн хөнөөсөн бэ, х.137
16. Энэ үеийн байдлыг, Ардчилсан Хувьсгалын Удирдагчийг Хэн хөнөөсөн бэ, мөн Арван Халуун Өдөр, тодорхой өгүүлсэн байдаг.
17. “Үүрийн Жавар”-т, Социал Демократ намын тэргүүн Б.Батбаяран Засгийн Газрын гишүүн болсон явдал, түүнээс өмнө Улсын Бага Хурлын даргаар Гончигдорж томилогдсон явдлуудыг дүгнээд, Ардчилсан хөдөлгөөн нь эсрэг байр суурьтай болсон гэж өгүүлсэн байдаг, х.142
18. Х.Дашзэвэг, МАҮН-ын Түүхэн Тэмдэглэл, Улаанбаатар, 1998 “Үндэсний Ардчилсан Намын түүх” х.122-123
19. Ардчилсан Хувьсгалын Удирдагчийг Хэн хөнөөсөн бэ, х.80
20. Үүрийн Жавар, х.144
21. Арван Халуун Өдөр, х.22
22. Үүрийн Жавар, х.145
23. Намжим “Монголын өнгөрсөн ба ирээдүй” Монголын Угсаатны зүйн музей, Хиого муж, 1998 он

*“Монгору кэнкю” сэтгүүлийн 2002 оны №19-ийн 40-49-р талаас япон хэлнээс орчуулсан Ж.Уянга*